



“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК – ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 1

Улаанбаатар

Г

Г

Гүйцэтгэх захирал томилох тухай

Компанийн тухай хуулийн 76.1.8 заалт, “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн эчнээ санал хураалтын саналыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Гүйцэтгэх захирал Батсүх овогтой Мянганбаяр-г үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.
2. Компанийн Гүйцэтгэх захирлаар Нарангэрэл овогтой Батгэрэл-г томилсугай.
3. Гүйцэтгэх захирал Н.Батгэрэлд компанийн тамга тэмдэг, дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээ, танилцуулга, санхүүгийн тайлан мэдээлэлийн бичиг баримтууд, тендерийн саналын материалууд, ХЭХ хурал болон ТУЗ-ийн хурлын материалууд, гарсан тогтоол зэрэг холбогдох баримт бичгүүдийг хүлээлгэн өгөхийг Б.Мянганбаярт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/ Ж.ЭРДЭМБИЛЭГ /



“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК – ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 2

Улаанбаатар

Г

Г

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60-р зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн “Хот Девелопмент”ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Хот Девелопмент” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 04 сарын 25-ны өдрийн 15 цагт Улаанбаатар хот, Сухбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, БиДиСЕК Компанийн төв байранд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - а) Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - б) 2018 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах;
 - с) Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
 - д) ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийн сонгох;
 - е) Компанийн ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин, ТУЗ-ийн зардлын төсвийг батлах тухай
 - ф) ТУЗ-с гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг “Хурал хуралдуулах тухай зар”-ыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 19 дэх өдөр буюу 2019 оны 04 сарын 08-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт №1-ийн дагуу баталж, нийтэд мэдээлэх өдрийг ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш 5 дахь өдөр буюу 2019 оны 03 сарын 20-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын сонингоор мэдээлэх, хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2019 оны 04 сарын 4-ний өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт №2-оор баталсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №3-р баталсугай. Хавсралт №3-д заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн төв оффисд ирж танилцах боломжтой.

7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг Хавсралт №4-ийн дагуу баталсугай .
8. Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг хурал хуралдах өдөр буюу 2019 оны 04 сарын 25-ны 15:00 цаг хүртэл байхаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Д.Даянбилгүүн., хурал зохион байгуулах комиссийн даргаар Д.Шүрэнцэцэг, гишүүнээр А.Мөнх-Эрдэнэ, тооллогын комиссын даргаар Б.Ганди , гишүүнээр Т. Хонгорзул. нарыг тус тус томилсугай.
10. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Ж.ЭРДЭМБИЛЭГ/



**“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК – ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2019 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 3

Улаанбаатар

Г

Г

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга томилох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 78.1-р заалт болон “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн эчнээ санал хураалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн **Д.Даянбилгүүн-г** томилсугай.

ЗӨВШӨӨРСӨН:

- | | |
|------------------|--------|
| 1. Ж.ЭРДЭМБИЛЭГ | /..... |
| 2. Д.ДАЯНБИЛГҮҮН | /..... |
| 3. ЖЭЙМС ПАССИН | /..... |
| 4. Б.МЯНГАНБАЯР | /..... |
| 5. Б. ИТГЭЛ | /..... |
| 6. Г.ЗАЯА | /..... |
| 7. Т.ТАМИР | /..... |
| 8. Д.НАРАНГОО | /..... |
| 9. | /..... |

